МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 30 өдөр Дугаар А/543 Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт төсөвт
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Харилцаа холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3,4.1, Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдийн 19 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймагт Төрийн цахим үйлчилгээний хэлтэс шинээр байгуулагдаж аймгийн Засаг дарга, Цахим хөгжил харилцаа холбооны сайдтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний 2.3.17, 2.3.18 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд "Хурдан" брэндийн үйлчилгээ үзүүлэх 10,14-р багын байрыг Brandbook загварын дагуу тохижуулах, засварлахад 6,778,100 (Зургаан сая долоон зуун далан найман мянга нэг зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Батлагдсан 6,778,100 (Зургаан сая долоон зуун далан найман мянга нэг зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э. Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Төрийн цахим үйлчилгээний хэлтэс (Д.Сумаадагва)-т үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011219